

“НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР” БУЮУ “ИРГЭДИЙН ӨДӨР” ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЙЛАН

2014.10.30

Ховд

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлиг, Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2 дугаар заалтын дагуу “Нээлттэй хаалганы өдөр” буюу “Иргэдийн өдөр”-ийг зохион байгуулах төлөвлөгөөг сум, байгууллагуудаас хүлээн авч, аймгийн хэмжээний нэгдсэн график гарган, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж, биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2 дугаар заалтын Иргэдийн оролцоо-шууд ардчиллын хэлбэрийг хэрэгжүүлж, сум бүрд “Иргэний танхим” байгуулан, төрийн байгууллага, иргэнийг холбосон олон нийттэй харилцах арга хэмжээг тогтмол болгож, сар бүр 1 өдрийг “Иргэдийн өдөр” болгон зохион байгуулж, иргэдийн санал гомдол, эрэлт хүсэлтийг хүлээн авч, үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ гэж заасны дагуу сум бүр “Иргэний танхим” байгуулан, сар бүр 1 өдрийг сум байгууллагуудын иргэдийн өдөр буюу нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах хуваарь, ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж, өөр өөрсдийн ажлын үндсэн чиг үүрэг, онцлогтой тохируулан олон хэлбэрээр зохион байгуулж, иргэдэд тодорхой мэдээлэл өгч, зарим төрийн үйлчилгээг газар дээр нь үзүүлж иргэдийн санал, гомдол, эрэлт хүсэлтийг хүлээн авах, байгууллагын үйл ажиллагааг сурталчилах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэл хүргэх, товхимол сурталчилгааны материал тараах ажлуудыг хийжээ.

Сум, байгууллагуудын зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөр” буюу “Иргэдийн өдөр”-ийн 2014 оны эхний хагас жилийн ажлын тайлан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлиг, Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2 дугаар заалтын хэрэгжилтэнд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний тасгаар хагас жилд хийсэн ажилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэн, ирүүлсэн зөвлөмжийг сум, байгууллагад хүргүүлэн ажиллалаа.

Сум, албан байгууллага, агентлагууд “Нээлттэй хаалганы өдөр” буюу “Иргэний өдөр”-ийг өөр өөрсдийн ажлын үндсэн чиг үүрэг, онцлогтой тохируулан олон хэлбэрээр зохион байгуулж, иргэдэд тодорхой мэдээлэл өгч, зарим төрийн үйлчилгээг газар дээр нь үзүүлсэн нь чухал ач холбогдолтой болсон байна.

“Нээлттэй хаалганы өдөр” буюу “Иргэдийн өдөр”-ийг зохион байгуулсан талаарх сум байгууллагуудаас ирүүлсэн тайланг нэгтгэж гаргав.

Сум бүр Иргэний танхимийг байнгын ажиллагаатай болгож “Шууд ардчилал-иргэдийн оролцоо” хэлбэрийг байнга хэрэгжүүлэх арга зүйн зөвлөгөөгөөр хангаж,

сумын веб сайтаар төрийн үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй мэдээлэн ажиллаж байна.

Сум, байгууллагаас зохион байгуулсан “Нээлттэй хаалга”-ны өдрөөр 7 байгууллага, 2 сум Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолын хавсралт хүснэгтийн дагуу нийт 56 нэр төрлийн асуудлаар иргэдийн саналыг хүлээн авч шийдвэрлэж, хариу өгсөн байна.

Нэг.Албан байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөр”-ийн тайланд

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар 12 багийн нутаг дэвсгэрт 12 удаа нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, аймгийн газар зохион байгуулалтын 2014 оны төлөвлөгөөг иргэдэд сурталчилж төлөвлөгөөнд тусгагдсан газруудыг танилцуулах, газар олголтын талаарх мэдээлэл өгөх, хотын ерөнхий төлөвлөгөөний танилцуулга, замын улаан шугамд орсон айлуудын мэдээлэл, Газрын тухай хууль болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, тогтоомжийг иргэдэд сурталчлах, зөвлөмж гарын авлага тарааж энэ хугацаанд иргэдээс 7 санал гарч, 16 асуулт тавьж хариулт авсан байна.

Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс нээлттэй хаалганы өдрөө орон нутгийн телевизтэй хамтран зохион байгуулж, сум бүрт хүрч ажиллан, мөн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл сурталчлах зорилгоор “Бид бүтээж чадна” үзэсгэлэнг 9 сумын 18 бүлэг оролцуулан байр эзлүүлэн шагнаж урамшуулсан байна. Энэ хугацаанд Жаргалант сумаас 32, Дарви сумаас 2, Чандмань сумаас 3, Мөнххайрхан сумаас 6, Дуут сумаас 4, Цэцэг сумаас 4, Мөст сумаас 4, Булган сумаас 3 иргэн санал хүсэлт гарган шийдвэрлэж хариу өгсөн байна.

Хөдөлмөрийн хэлтсээс “Ажилтай орлоготой Ховд хүн” хөдөлмөрийн яармаг, хэлтэс сурталчлах өдөрлөгийг зохион байгуулж, хийсэн ажлаа танилцуулан, яармагийн үеэр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ажлын байрны захиалга авах, ажил идэвхитэй хайгч иргэдийг бүртгэх, зөвлөгөө өгөх, сул чөлөөтэй ажлын байруудыг нээлттэй зарлаж иргэдийг ажилд зуучлах зэрэг үйлчилгээнүүдийг иргэдэд үзүүлж, өдөрлөгөөр 25 ажил олгогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 70 гаруй ажлын байрыг нээлттэй зарлаж 13 иргэнийг ажилд зуучилж, ажил идэвхитэй хайж байгаа 34 иргэнийг ажилд зуучлан, 100 гаруй иргэнд зөвлөгөө өгч, 18 иргэнийг сургалтанд хамруулахаар анкет бөглүүлсэн байна.

Нийгмийн даатгалын хэлтэс нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх аяны хүрээнд зохион байгуулж шинээр 53 иргэнийг сайн дурын даатгалд хамруулж, эрүүл мэндийн даатгалд 34 иргэнийг шимтгэл төлүүлж, 78 иргэнийг баталгаажилтын хуудас тарааж, нийгмийн даатгалын 63 дэвтэр баталгаажуулж, 32 иргэнийг тэтгэврийн материал үзэж зөвлөгөө өгсөн байна. Энэ өдөрлөгөөр 10

өртөөнүүдийн зохицуулагч нар өөр өөрийн өртөөг удирдан чиглүүлж иргэдийн дунд уралдаан тэмцээн зохион байгуулж 1000 гаруй иргэд оролцсон байна.

Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсээс “Нээлттэй хаалга”-ны өдөр” үйл ажиллагааг “Насан туршийн боловсролын төв”, Бүсийн эмчилгээ оношлогооны төв, Хот тохижуулах “Эрч хүч” компани, Ард Аюушийн талбайд бүх нийтийн дунд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны алба хаагчид, тэдний гэр бүл нийт 400 гаруй иргэдийг оролцуулан сургалт, мэдээлэл хийж тэдний дуу хоолойг сонсож, үйл ажиллагааг олон нийтийн телевмээр сурталчилсан бөгөөд тухайн байгууллагын эцэг эхийн зөвлөл хэрхэн ажиллаж, хүүхэд хамгааллын бодлогыг үр өгөөжтэй хэрэгжүүлж, үйл ажиллагаа явуулж байгаа талаар судалгаа авч нэгтгэн дүгнэж байгууллагын удирдлагад хүргүүлсэн нь ихээхэн дүнтэй ажил болсон. Мөн баруун бүсийн даншиг наадам “Их хурд-2014” хурдан морины уралдаан зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан уралдаанч хүүхдүүдийг стандарт шаардлага хангасан хувцас өмсүүлэх, мэдээлэл өгөх, хяналт шаардлага тавихад анхаарч нээлттэй хаалганы өдрийг энэ үеэр зохион байгуулж 324 уралдаанч хүүхдийг бүртгэж, 100% даатгалд хамруулан, эмчийн үзлэгт хамруулан, хамгаалалтын малгай өмсүүлсэн. Мөн нээлттэй хаалганы өдрийг Насан туршийн боловсролын төв, Залуучуудын хөгжлийн төв, бусад төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.

Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж, музейн үйл ажиллагааг харуулсан зургуудаар үзэсгэлэн гаргаж, өв соёлын хүрээлэнгийн үзмэрүүд, хатгуур гэр, жолом гэрийг барьж ард иргэдэд үйлчилжээ. Мөн 12 жилийн 1-р сургуулийн 6 В ангийн 34 сурагчдад “Миний нутгийн түүх” сэдвээр аймгийн Музейд хичээл зааж, аймгийн нутаг дэвсгэрийн талаар мэдээлэл өгч, түүхэн дурсгалт зүйлийн талаар харилцан ярилцаж, түүх нийгмийн алдартай хүмүүсийн нэрэмжит газруудын талаар харилцан ярилцаж мэдлэг олгосон байна.

ХДТеатр нээлттэй хаалганы өдрөөр иргэдээс судалгаа авч цаашид хийх уран бүтээлийн чанарт анхаарах, уран бүтээлийг үнэлэх үнэлэмжийг нэмэгдүүлсэн.

Нийтийн номын сангаас “Ховдчууд уншиж байна” 14 хоногийн аян зохион байгуулж, “Ном ухаарахуйн үндэс мөн” сэдэвт онол практикийн бага хурал, “Уншигчдад үйлчлэх нэг өдөр” зэргийг зохион байгуулж шинэ номын, ховор номын үзэсгэлэн зохион байгуулсан байна. Энэ үеэр явуулын номын сан ажиллуулж ном унших үйлчилгээг үзүүлжээ.

Прокурорын газраас үйл ажиллагааг олон нийтэд хүргэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээний хүрээнд иргэдэд мэдээлэл хүргэн, гарын авлага тараан прокурорын хяналтын ажлын мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох үйл ажиллагааны шударга байдлыг сайжруулахад чиглэсэн 50 иргэдийг хамруулан судалгаа авсан.

Улсын бүртгэлийн хэлтэс Нээлттэй хаалганы өдрөөр Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг 63 иргэнд лавлагаа, 12 иргэнд зөвлөгөө өгч, хуулийн этгээдийн бүртгэлээр 18 иргэний аж ахуйн нэгжид зөвлөн туслаж, хүсэлт тавьсан 27 иргэнд лавлагаа өгч, 67 иргэнийг бүртгэлийн санд оруулсан байна.

Худалдан авах ажиллагааны хэлтэс 14 сум, аймгийн төвд худалдан авах ажиллагааны мэдээлэл, тендер шалгаруулалт, шилэн тендер, ил тод худалдан авах ажиллагаа, олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаа, цахим тендер зэрэг хэлэлцүүлэг, сургалт, телевизийн нэвтрүүлэг, зөвлөгөө өгч ажилласан байна.

Цагдаагийн газар нь байгууллагынхаа үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах, цагдаагийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, хүнд суртал гаргахгүй байх, гэмт хэрэгтэй тэмцэх нийгмийн хэв журам хамгаалах ажилд иргэд, олон нийтийн оролцоо, тэдний дэмжлэг туслалцааг өргөжүүлэх, хамтран ажиллах зорилгоор сар бүр “Нээлттэй хаалганы” арга хэмжээг зохион байгуулж хэвшсэн байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 8 төрлийн санамж, сэрэмжлүүлэгийг 1050 ш тараан өгч санал хүсэлтийн хайрцаг ажиллуулж амаар болон бичгээр 21 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаж холбогдох хуулийн дагуу шийдвэрлэсэн. Хууль эрх зүй танин мэдэхүйн чиглэлээр АХА тэмцээнийг Ховд их сургуулийн эрх зүйн ангийн оюутнуудын дунд зохион байгуулсан.

Сум дундын ойн анги мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж албан байгууллагуудын дунд зохион байгуулж, нээлттэй хаалганы өдөрлөгөөр хаврын мод тарьсан газарт нөхөн тарилт хийж арчилж хамгаалах ажлыг зохион байгуулж, 56 байгууллага, 14 сумын 3740 хүн хамрагдаж 13092 ширхэг мод тарьснаас 3476 ш бут сөөг таригдаж нийт 5 688 300 төгрөгийн зардал гаргав.

Стандартчилал, хэмжил зүйн хэлтсээс “Хэмжил ба эрчим хүчний дэлхий дахинд тулгамдаж буй асуудал” уриан дор Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авах ажлыг зохион байгуулж бизнес эрхлэгч, төрийн байгууллага, үйлчилгээ эрхлэгчдийг оролцуулан нээлттэй хэлэлцүүлэг хийж санал солилцож стандартын хэрэгжилтийн талаар сургалт зохион байгуулж сурталчилсан байна. Мөн 3 суманд нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, 6 аж ахуйн нэгжийн 2 нэр төрлийн 20 бүтээгдэхүүнд тохирлын үнэлгээ хийснээс тохирлын гэрчилгээ хэрэглэх эрхийн хугацаа дууссан 1 аж ахуйн нэгжийн 5 нэр төрлийн бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ хэрэглэх эрх олгожээ.

Хар нуур Ховд голын сав газрын захиргаанаас “Ус чандмань эрдэнэ” хүний амьдралын үнэт хэрэглээ юугаар ч орлуулшгүй байгалийн баялаг” уриан дор нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж Буянт голын цэвэрлэгээний үйл ажиллагааг орон нутгийн Эко ТВ-тэй хамтран зохион байгуулж 47 байгууллага аж ахуйн нэгж оролцож, цэвэрлэгээний дараа АХА тэмцээн зохион байгуулжээ.

Тээвэр авто замын газар гамшгаас хамгаалах зам, тээврийн албаны бүтэц, зохион байгуулалт гамшгийн үед тээвэр авто замын газраас авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, тайланг танилцуулж гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн үйл ажиллагааг сурталчилж, 7 төрлийн 200 гаруй гарын авлага тараасан.

Байгаль орчны газраас “Ногоон байгууламж”-ийн хэлэлцүүлэг, “Ус ба эрчимт хүч”, “Эх дэлхийн цаг-2014” арга хэмжээг зохион байгуулж, байгаль орчны мэдээллийг сурталчлах, мод суулгац, үр үрсэлгээний үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, онгон дагшин байгаль, агнасан биш амьд амьтнаараа бахархах, иргэдийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх экологийн боловсролыг дээшлүүлэд чиглүүлэн зохион байгуулжээ. 5 сумын ЕБС-ийн сурагчдын дунд “Дэлхийн усны өдөр”, “Ус амьдралыг тэтгэгч чандмань эрдэнэ”, “Ус ба эрчим хүч”, “Хог хаягдлыг бууруулах арга зам” сэдвээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулжээ.

Онцгой байдлын газар аврах ажиллагааны болон гал унтраах авто машин, техник хэрэгсэлийг дэлгэн үзүүлж 20 цагийн сурталчилгаа хийж, нийт 1500 ширхэг сурталчилгааны хуудас тарааж үйл ажиллагаагаа сурталчилсан. Эрүүл мэнд салбар зөвлөлтэй хамтран Алтай, Булган, Үенч сумдад “Хүн малын гоц халдвар, халдварт өвчний үед хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх нь” сэдэвт онолын болон үзүүлэх сургуулийг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж 7 сургуульд аврах ажиллагааны зарим нэр төрлийн багаж хэрэгсэл гардуулж, телевиз хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран үйл ажиллагаагаа сурталчилсан байна.

Шүүхийн шинжилгээний алба нь албаны байрандаа нээлттэй хаалганы өдрийг 3 удаа зохион байгуулж, ХоИС-ийн эрх зүйн ангийн оюутнуудад албанд ашиглагдаж буй техник, хэрэгслийг танилцуулж, мэдээлэл өгч сонирхсон асуултанд хариулт өгсөн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба нээлттэй хаалганы өдрийг байгууллага дээрээ болон хуулийн байгууллагуудтай хамтран мөн “Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх нээлттэй өдөр” зохион байгуулж, 173 иргэнтэй уулзаж байгууллагын үйл ажиллагааг сурталчилан танилцуулж санал хүсэлтийг нь авсан. Мөн тус хорих ангид ял эдэлж байгаа ялтнууд болон тэдний ар гэртэй өдөр бүр нээлттэй уулзалт зохион байгуулж, давхардсан тоогоор 231 ялтан, ар гэрийн 1119 иргэний санал хүсэлтийг нь хүлээн авч шийдвэрлэн санал асуулга судалгаа явуулж, зөвлөгөө өгч, байгууллагын үйл ажиллагааны талаар сурталчилсан байна.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар намрын үзэсгэлэн худалдаа шилмэл малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулж газар тариалангийн намрын ургац хураалтын дүн, тариаланчдын ургацын дээжээр үзэсгэлэн гаргаж 20 гаруй тариаланч оролцсон байна. Шилмэл малын үзэсгэлэн худалдаанд 8 сумын 80 гаруй мал оролцож шалгарсан гойд ашиг шимт малд алт мөнгө хүрэл медаль олгон бүртгэлийн санд бүртгэн баяжилт хийжээ.

Эрүүл мэндийн газар хүүхэд болон эцэг эхчүүдэд осол, гэмтэл, хүүхдийн амны хөндийн эрүүл мэнд, хөдөлгөөний ач холбогдол зэргийг бүжгээр сурталчлан ЕБС-ийн 7 сургуулийн 8 баг оролцож, 6 байгууллагын дунд “Эрүүл ажлын байр” дэвжээ тэмцээнийг зохион байгуулсан. 5 өрхийн эрүүл мэндийн төвийг оролцуулан хүүхдийн парк дээр өдөрлөг хийж Буянт ӨЭМТ “Эрүүл гудамж-миний хашаанаас”, Баатархайрхан ӨЭМТ “Амны хөндийн эрүүл мэнд”. Жаргалан ӨЭМТ “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, Буянт ӨЭМТ “Эх хүүхдийн эрүүл мэнд”, Рашаант ӨЭМТ “Хүүхдийн осол гэмтлээс сэргийлье” уриан дор сургалт сурталчилгааны ажлыг хийж 40 хүний цусны даралт, 38 хүүхдийн жин өндөр, 43 хүний өндөр жин, 39 хүний цус сахар тодорхойлж, 40 хүнд эрүүл мэндийн зөвлөгөө өгсөн.

Иргэний хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүх, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүх шүүхийн шинэтгэлийн талаар олон нийтэд мэдээлэл өгөх, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг шүүхийн байгууллага хэрхэн хамгаалдаг талаар иргэдээ мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор Иргэн, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүхийн Тамгын газрын даргын 2014 оны 63 дугаар тушаалаар “Нээлттэй шүүх” арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөөг баталсан байна. Нээлттэй шүүх арга хэмжээг аймгийн төвд Ард аюушийн талбайд, өдөр тутам хөдөлмөр эрхлэдэг иргэд олноор цуглардаг газарт иргэдэд хүрч ажиллах зорилгоор Баруун бүсийн төв зах, Жаргалант сумын Буянт багийн 2,3-р гудамжинд, Баатархайрхан багт, орон нутгийн хэвлэл, мэдээлэлийн байгууллага, сэтгүүлчдэд, “Нээлттэй шүүх-сумдад” арга хэмжээг Булган суманд зохион байгуулж арга хэмжээнд 18649 иргэд хамрагдсанаас 847 иргэд санал хүсэлтээ өгч иргэдийн санал хүсэлтэд тулгуурлан дараагийн ажлаа төлөвлөж хэрэгжүүлэн ажилласан байна. Мөн шүүхийн вэб сайтыг бүрэн ашиглалтад оруулж цаг үеийн мэдээллээр тогтмол мэдээлж байна. Жаргалант сумын ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад “Хууль бидний амьдралд-Шүүхийн шинэтгэл” сэдвээр хэлэлцүүлэг хийж, “Нээлттэй шүүх” өнгөт сэтгүүл, гарын авлага материал өрх бүрт тарааж, багуудын ИНХ-д шүүхийн шинэтгэлийн талаар мэдээлэл хийсэн байна.

ЗӨСтөвөөс Үенч суманд тарваган тахлын хүний өвчлөлийн үзүүлэх сургалт зохион байгуулж, үзүүлэх сургуулийг тарваган тахал өвчнөөр өвчилсөн үед орон нутгаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг бодит байдлаар тоглон харуулж сумын удирдлага иргэдэд мэдээлэл өгч, урьдчилсан өгөгдөл боловсруулж бэлтгэл ажил хийсэн. Жаргалант суманд иргэд олноор цуглардаг Зах, БОЭТ зэрэг газар байгууллагын үйл ажиллагааг сурталчилж тарваган тахлын 450 ш, галзуу өвчний 387 ш, хачиг халдварын 687 ш, шувууны томууны 381 ш тараах материал тараасан.

БОЭТ-өөс “Хавдрын эсрэг үндэсний аян 2014” БОЭТ-д 2014 оны 06 сарын 09-ны өдөр нээлтээ хийж, Хавдар судлалын үндэсний төвийн хавдрын мэс засал, ходоод гэдэсний мэс засал, эхо, дуран, толгой хүзүүний мэс засал, эмэгтэйчүүдийн хавдар судлаач эмч, сургалтын арга зүйч зэрэг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр 5 хоног үзлэг, мэс засал гэсэн үндсэн чиглэлтэй ажиллаж, сум, багийн иргэд малчдыг түлхүү хамруулахыг зорьж ажиллан хавдрын эсрэг аян орон даяар 3 жил дараалан амжилттай хэрэгжиж нийт 5500 орчим иргэнийг үзлэг

оношлогоонд, аймаг, дүүрэг, сум, өрхийн 3150 орчим эмч мэргэжилтэнийг сургалтанд хамруулж, 1300 гаруй сайн дурын идэвхтнийг бэлтгэжээ.

Монголын залуучуудын өдрийг тохиолдуулан аймгийн залуучуудын холбоо, БОЭТ-ийн залуучуудын зөвлөлөөс санаачлан “Залуус бид нэгдэж хүний амийг аварна уриан дор “Цусаа бэлэглэцгээ” нээлттэй хаалганы өдөрлөг амжилттай зохион байгуулсан бөгөөд нүд, шүд, чих хамар хоолой, дотор, мэдрэл, трансфузиологич гэсэн 6 төрлийн нарийн мэргэжлийн эмч нарын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, сургалт, сурталчилгаа хийж 80 гаруй залуусыг хамруулж, нийгмийн сайн сайхны төлөө өөрсдийн үүргээ ухамсарлаж эрдэнэт хүний алтан амийг аврах ариун үйлсэд нэгдэн 12 залуу донор болсон.

Мөн “Элэгний хавдрыг эрт илрүүлье” нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, өдөрлөгийн хүрээнд Хорт хавдар түүний эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн ач холбогдлын талаар өсвөр үеийн залууст зориулсан Khovd BOET – Palliative care цахим хуудас ажиллуулан тус төвөөр үйлчлүүлж байгаа иргэдэд хорт хавдрын талаарх ойлголт, хэрхэн урьдчилан сэргийлэх тухай мэдээлэл хийж, үйлчлүүлэгчдэд үзлэг хийж зөвлөгөө өгч нийт 3000 гаруй ном, гарын авлага, сэтгүүл тарааж, 56 хүнд үзлэг хийсэн байна.

Хөгжил Политехник коллеж хөдөлмөрийн салбарын баярын өдрийн хүрээнд “Миний чадвар” нээлттэй хаалганы өдөрлөг хийж, өдөрлөгөөр мэргэжлийн ангиудын ур чадварын үзүүлбэр, бүтээлийн үзүүлбэр, үзэсгэлэнг аймгийн төв талбай дээр гаргаж түншлэгч байгууллагуудын төлөөлөл, үе үеийн төгсөгчид, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, аймгийн удирдлагууд, иргэд хөдөлмөрчид оюутнууд оролцож, мөн 2014 оны 10 сарын 02-ны өдөр аймгийн хөдөлмөрийн хэлтэстэй хамтран төв талбай дээр “Ажилтай орлоготой-Ховд хүн” нээлттэй хаалганы өдөрлөгөөр тус сургуулийн багш суралцагсадын хийсэн нутгийн бренд бүтээгдэхүүн, тухайлбал: Алимны компот, үхрийн нүдний компот, варени, алаг салат, огурцы, хүнсний ногооны дээж, талх нарийн боовны үзэсгэлэн гаргаж, иргэдэд танилцуулж сургуулийн үйл ажиллагааг тус утс сурталчилсан.

ХУНОУТХГН-ын хамгаалалтын захиргаанаас “Дэлхийн усны өдөр” ийн хүрээнд усны үнэ цэнэ, ач холбогдлын талаар иргэдийн санал хүсэлтийг авч сурталчилгааны материал тарааж, тусгай хамгаалалттай газар нутагт амьдарч байгаа иргэдээс байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийн талаар санал асуулга явуулах, шувууны томуу өвчнөөс урьдчилан сэргийлэх, бургас болон бутлаг ургамал, бэлчээрийн зүй зохистой ашиглалт, аялал жуулчлалыг хөгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, тусгай хамгаалалттай газар нутгийн газар, ашиглалт, талаар иргэдийн санал, зөвлөгөөг авах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх түүний хор хөнөөл, анхаарах асуудлын талаар сэрэмжлүүлэг тарааж энэ талаар ард иргэдийн санаа бодлыг сонсож цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн төв, тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн сумууд, багуудын хурлаар нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж ажилласан.

Ховд их сургууль нь салбар болон бүрэлдэхүүний сургууль, тэнхим, нэгжүүдийн үйл ажиллагааг сурталчилан үзэсгэлэн гаргах, элсэлт, төгсөлтийн үеэр мэргэжил сурталчилсан анонс, сурталчилгааны материал, танилцуулга, тэнхимүүдийг сурталчилсан үзэсгэлэн гаргаж, мэргэжлийн анги бүр мэргэжил сурталчлах нэг өдрийн аянг сургууль дээр зохион байгууллаа. Мөн мэдээллийн ил тод байдлыг ханган 70438823 дугаарын нээлттэй утсыг хичээлийн жилийн турш ажиллуулж, иргэдээс 41 санал хүсэлт хүлээн авч шийдвэрлэж, хариуг өгч, орон нутгийн телевизээр сургуулийн үйл ажиллагааг сурталчилсан 14 нэвтрүүлэг явуулж, сургуулийн захирал 8 удаа ярилцлага, мэндчилгээ явуулсан байна. Инноваци инкубатор төвийн үйл ажиллагаа эхлүүлж, орон нутагт сурталчлан төвийн үйл ажиллагааг эхлүүлж, эрдэм шинжилгээ судалгааны 6 төслийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, үйл ажилаагааг нь эхлүүлээд байна.

Татварын хэлтэс татвар төлөгчдийн өдөрлөгийг нээлтээ аймгийн төвд Ард Аюушийн талбайд хийж, 40 гаруй бизнес эрхлэгч аж ахуйн нэгж болон иргэнээр татвар төлөгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн гарган, гарын авлага брошур, сониныг Эко-Ховд ХХК-р хэвлүүлэн татвар төлөгч ААНБ, иргэдэд тараан сурталчилсан байна. Мөн Нийтийн тээврийн хэрэгслийг ашиглан зурагт хуудас байршуулан, “Татвар эрүүл ирээдүйг” сэдэвт зурагт хуудас гарган ирээдүйн татвар төлөгчдөд зохион бичлэг, шүлэг, гар зургийн уралдаан зохион байгуулж, аймгийн татварын хэлтсийн үйл ажиллагааг сурталчилсан байна. Булган, Алтай, Үенч сумуудад очиж нээлттэй хаалганы өдрүүдийг зохион байгуулжээ. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад болон багш ажилчдад татварын талаархи сургалт сурталчилгаа хийж, татвар төлөх сэтгэлгээг багаас нь төлөвшүүлэх татвар төлөх үүргийг эцэг эхүүдэд нь хүүхдээр дамжуулж хүргэх замыг туршилтаар сургалт явуулж, сургалтыг ерөнхий боловсролын 3-р сургууль дээр 3 ангид явуулж сургалт үр дүнгээ өгч байгаа тул сургалтыг цаашид өргөн цар хүрээтэй явуулахаар төлөвлөж байна.

Хоёр: Сумдын Засаг даргын Тамгын газар, албан байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөр”-ийн тайланд

Алтай сумын ЕБС-аас сургуулийн дотуур байр сурталчлах сарын аян зохион байгуулж, сургуулийн гал тогооны үйл ажиллагаа сурталчилж, хоолны үзэсгэлэн гаргасан. Зөв хооллолт, эрүүл мэндийн талаар сургалт, АХА тэмцээн зохион байгуулсан байна.

Булган сумын ЕБСургууль эцэг эхийн дунд “Эцэг эхийн хишиг өдөр” 2 өдрийн арга хэмжээ, “Эх хэлээ хайрлацгаая” тэмцээн, “Сурагч эцэг эх” сэдэвт нээлттэй хичээл, АХА тэмцээн зохион байгуулж, сумын Засаг даргын Тамгын газар, Соелын төв, Хүүхдийн цэцэрлэг, Зэвсэгт хүчний 305 –р анги, 26 дугаар шүүх, Алагтолгой баг, Бүрэнхайрхан баг, Баянсудал багууд тус тус нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулсан байна. Булган сумын Аврах, гал унтраах 38 дугаар анги “Гамшгийн тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах”, “Гамшгийн үед хүч хэрэгслийг дайчлан нүүлгэн шилжүүлэх” арга хэмжээг иргэд, аж ахуйн нэгжийг хамруулан зохион байгуулжээ.

Мөст сумын Засаг даргын Тамгын газраас сумын нээлттэй хаалганы өдрийг Соёлын төвд нэгдсэн журмаар зохион байгуулж, нэг цонхны үйлчилгээг 66 иргэнд үзүүлж, 500 иргэнээс санал асуулгын хуудсаар санал авч төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, мэдээллийг иргэдэд хүргэж ажилласан байна. Хүүхдийн цэцэрлэгийн нээлттэй хаалганы өдрөөр “Бага бүлэг таны хүүхэд 2 нас” сэдэвт ярилцлага, “Үлгэрийн баатрууд амилсан нь” жүжигчилсэн тоглолт хэл яриа харилцааны чиглэлээр үйл ажиллагаа явуулсан. ЕБСургууль хүүхдийн хөгжилд хүүхдийн оролцоо сургалтын дүнгийн талаарх хэлэлцүүлэг, Хүн эмнэлэг “Эрүүл мэндийн үзлэгт хамруулах аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх аргад сургах” сэдвээр 56 айл өрхөд хүрч ажиллан 68 иргэнд эрүүл мэндийн зөвлөгөө өгч 46 хүн үзэж оношилж, 12 жилийн дунд сургуулийн 670 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, хөдөөгийн малчин эцэг эхчүүдийн дунд “Эрүүл мэндийн боловсрол олгох” сургалт зохион байгуулсан байна.

Буянт сумын ИТХ, ЗДТГ хамтран “Ургацын баяр 2014” наадмаар нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж, иргэний танхимаас иргэдэд ИНХ-д хэрхэн оролцох талаар сургалт, Ховдын мэдээ сонинд 2014 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан нийтлүүлж иргэдэд тарааж, иргэдийн дунд хамгийн том ногоонууд, хамгийн сайн нөхөрлөл бүлгийг шалгаруулан урамшуулсан. Мөн ахмадын баяраар нээлттэй хаалганы өдрийг 5 баг дээр зохион байгуулж ахмадуудад хүндэтгэл үзүүлж, урлагийн тоглолт сонирхуулж хөгжөөнт тэмцээн зохион байгуулсан. “Эрүүл мэндийн довтолгоо” аяны хүрээнд 5 багт зохион байгуулж 307 хүн үзлэг хийж, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 61, диспансерийн хяналт 22, гэрийн идэвхитэй эргэлт 68 хийж үйлчилсэн. Албан байгууллагуудаар байгууллагын үйл ажиллагааг сурталчлан 115 төрийн албан хаагчид чихрийн шижингийн шинжилгээ, цусны шинжилгээ, хараа, жин хэмжих болон эрүүл мэндийн зөвлөгөө өгч, 3 санал ирснийг шийдвэрлэсэн байна.

Цэцэг сум. Нийгмийн халамжийн чиглэлээр нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж, “Алтан хонх” тэмцээнийг хуулийн асуултаар явуулж, 29 иргэнд таяг, нүдний шил, бүслүүр, тэргэнцэр олгосон байна. Ахмадын баяраар байнгын асаргаанд байдаг 21 ахмад настанг гэрээр эргэж нийт 133 ахмадад гарын бэлэг нийгмийн халамжаас олгосон. Мөн ахмадуудын дунд шатар, даамны тэмцээн, цэнгүүн зохион байгуулжээ.

Зэрэг сумын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагууд нээлттэй хаалганы өдрөөр иргэдийн дунд нэн тэргүүний тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор сумын татварын байцаагч, газрын даамал, нийгмийн даатгалын байцаагч, нийгмийн халамжийн мэргэжилтэн болон холбогдох бусад мэргэжилтнүүдийг оролцуулан иргэдийн санал хүсэлт, гомдол шийдвэрийг хүлээн авч үйл ажиллагаандаа тусган асуудлыг шийдвэрлэх болон хууль эрх зүйн мэдээ мэдээлэл өгч ажилласан байна.

Дарви сумын ЕБСургуулийн заах аргын нэгдэлүүд өөрсдийн багш сурагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргаж оролцогчдыг 4 багт хувааж “Орон нутгийн хөгжил-

Хүний хөгжил"-өөс сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулан, хэлэлцүүлгийг "Алжаал тайлах", "Мөрөөдлийн сум", "Таны миний бидний үүрэг оролцоо", "Харилцаа ба хамтын хүч", зэрэг 4 өртөөгөөр аялуулсан байна. Хэлэлцүүлгийн үдийн цай хөтөлбөр, сургуулийн үйл ажиллагаатай танилцав."Эцэг эхийн нэг өдөр"-ийг зохион байгуулж, эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлж, санал сэтгэгдлээ солилцож, судалгаа авч эрхлэгч болон багш, туслах багш нарын үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ өгүүлжээ.Эцэг эхчүүдэд зориулж "Хамтдаа уншия", бага насны хүүхдийг хөгжүүлэх нь" сургалт, "Угийн бичиг хөтлөхийн ач тус, эрүүл саруул удамтай байхын төлөө" сэдэвт сургалт хэлэлцүүлэг зохион байгуулж уг сургалтанд нийт 170 хүн хамрагдсан байна.

Соёлын төв нь "Номын баяр" аймгийн нийт номын санчдын өдөрлөгийг сумандаа зохион байгуулж, аймаг болон сумдын нийт 31 номын санч урилгаар оролцлоо. Энэ үеэр Монголын "Нууц товчоо" залах ёслол, сумын номын сангийн үйл ажиллагаатай танилцах, сургалт мэдээлэл, түүх соёлын дурсгалт газраар аялах хөтөлбөрийн дагуу үйл ажиллагааг зохион явуулсан

Мөнххайрхан сумын Засаг даргын Тамгын газраас мал эмнэлэг үржлийн тасаг, газар, байгаль орчны чиглэлээр нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, иргэдэд хууль сурталчилах, санал хүлээн авч, Эрүүл мэндийн төв "Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих" сэдвийн дор иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт хийж, 78 иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. "Архи эрүүл мэндэд нөлөөлөх нь", "Бухимдлаа тайлах арга зүй", "Осол гэмтэл","Эмийн бус эмчилгээ" зэрэг сургалтууд зохион байгуулжээ. Мөнххайрхан уулын БЦГХЗахиргаа "Мөнххайрхан сумын байгаль экологи, түүх соёлын зарим асуудлууд" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан байна.

Дөргөн сум сум сурталчилах соёлын өдрүүдийг 10 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд зохион байгуулж, уламжлалт 100 тэмээн жингийн цуваа, ганжуурын 108 боть, нутгийн бүтээгдэхүүн цагаан давс, хужир ачин сумын төвд байрлах Амгаланг үүсгэгч Майдар гэгээний хийдийн өмнөөс хөдөлж, тэмээн жингийн цуваанд 35 жинчин, сумын Засаг дарга, Тамгын газрын дарга, Майдар гэгээний хийдийн лам нар оролцож 3 өдрийн турш явж 10 дугаар сарын 26-ны өдөр аймгийн төв Галдан бошгот хааны талбайд сум сурталчилах нэг өдрийн үйл ажиллагаа эхэлсэн. Энэ үеэр Ганжуурын 108 ботийг тахилын гэрт залж, сумын үзэсгэлэн гаргаж, музейн үзмэрүүд, үндэстний өв уламжлалаас танилцуулж, дөрвөд түмний өв уламжлал ёс заншлыг шингээсэн урлагийн тоглолт тоглосон байна.

Дуут сумын Засаг даргын Тамгын газраас "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ сонсоё" нээлттэй хаалганы өдрөөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж, тэдний санал хүсэлтийг сонсож, үйл ажиллагааны төлөвлөгөө гаргав. Эрүүл мэндийн довтолгоо аяны хүрээнд хөдөөгийн 3 багт нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж урьдчилан сэргийлэх үзлэгт 165, шинжилгээнд 48, сургалтанд 71, чийрэгжүүлэлтийн сорилд 46 иргэд тус тус хамрагдав. Залуучуудын холбоотой хамтран өглөөний дасгал хөдөлгөөн, гүйлт, ЕБС-ийн сурагчдын дунд архи тамхины хор хөнөөл сэдэвт сургалт, Цэцэрлэгийн

хүүхдүүдэд амны хөндий , гарын ариун цэврийн сургалт зохион байгуулж, иргэдтэй хамтарч ажилласнаар Хөх бэлчир багийн малчин М.Батхүү, Шивэр багийн малчин С.Чинбат нар бага, ахлах бүлгүүдэд тоглоом хандивласан бол ЕБСургууль “Эцэг эхийн нэг өдөр” -өөр эцэг эхчүүдэд сургуулийн үйл ажиллагааг сурталчилан хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагааны талаар санал хүсэлт авч, тэмцээн хэлэлцүүлэг хамтран зохион байгуулсан байна. Соёлын төв “Алтан өв” соёл урлагийн өдрийг Ховд аймагт зохион байгуулж, урианхайн язгуур урлаг өв соёлыг харуулсан 80 гаруй уран бүтээлчид оролцсон тоглолт хийж, хишиг барилдаан сурын харваа зохион байгуулсан.

Ховд сум хөдөөгийн 4 багийн иргэдэд малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арьс шир ноосны урамшуулал, хоршооны талаар мэдээлэл хийж санал хүсэлтийг хүлээн авч зөвлөгөө өгч ажилласан. Мөн сумын Хүүхдийн Цэцэрлэг, Соёлын төв, ЕБС, Цагаан бургас баг тус тус нээлттэй хаалганы өдөр зохион байгуулжээ.

Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газраас нийтийн албан тушаалтнуудыг чадавхижуулах нь сэдвийн дор холбогдох хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулж, “Төрийн үйлчилгээг малчны хотонд” “Таны өдөр”, “Нийгмийн хамгааллын нээлттэй хаалганы өдөр, “Дотуур байрны хүүхдийн эцэг эхийн нэг өдөр”, Иргэдийн өдөр, “Бэлчээрийг зөв ашиглая” нээлттэй хаалганы өдөр зэрэг нээлттэй хаалганы өдрөөр сургалт, сурталчилгаа, мэдээ мэдээлэл хийжээ.

Үенч сумын Жаргалан, Цагаан түнгэ баг 3 дугаар сарын 14, Нарийн гол баг 4 дүгээр сарын 25-нд нээлттэй хаалганы өдөр зохион байгуулахад сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүд ажлаа сурталчилсан тухай 3 удаагийн арга хэмжээний зохион байгуулжээ. 2014 оны 10 дугаар сард зохион байгуулсан Нээлттэй хаалганы тайлангаа ирүүлээгүй.

Манхан сумын Засаг даргын Тамгын газраас хөдөөгийн 5 багт нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж, хууль эрх зүйн болон цаг үеийн ажлын мэдээлэл өгч гарын авлага материал тарааж АХА , волейболын тэмцээн зохион байгуулж иргэдийн санал хүсэлтийг сонссон байна. Хүүхдийн цэцэрлэг эцэг эхчүүдийг оролцуулан 5 удаагийн нээлттэй хичээл зааж санал хүсэлтийн дэвтэр аялуулсан байна. Эрүүл мэндийн төв “Эрүүл мэнд- Эрхэм дээд баялаг” сэдэвт өдөрлөг зохион байгуулж, 112 иргэнд зөвлөгөө өгч, үйлчилгээ үзүүлсэн байна. Соёлын төв “Соёлын өв” сэдвээр Дэвжээ тэмцээн зохион байгуулсан.

Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын нийгмийн халамж, хамгааллын чиглэлээр “Төрийн үйлчилгээг түмэндээ”, байгаль орчны чиглэлээр “Байгаль ээж бидний гэр” сэдвээр үзүүлэн хэлбэрээр, татварын хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд “Төр оршихуй дор татвар буй”, иргэний бүртгэлийн чиглэлээр “Нэг иргэн- нэг бүртгэл”, мал эмнэлэг хүнсний чиглэлээр нээлттэй хаалганы өдөр, ЕБСургууль “Хүүхэд бүрийн хөгжлийн төлөө хамтдаа” өдөрлөг, эх хэлний “Тунгаамал” тэмцээн, Эрүүл мэндийн төв Баянхошуу багийн иргэдийн дунд

“Хүүхдийн нэмэгдэл хоол” сэдэвт үзүүлэх сургалт, “Сувилагчийн нэг өдөр”, “Гэр бүл төлөвлөлт” сургалт, Цэвэр агаар эрүүл мэндийн өдөрлөг, “Заавал биелүүлэх 21 дадал” сэдвээр, мөн ЗДТГ, ЕБС, ЭМТ хамтран “Хамтдаа инээмсэглэе” хүүхдийн анхдугаар чуулган, Соёлын төв үйл ажиллагаа сурталчилан “Агшин” тэмцээн тус тус зохион байгуулж, сургалт сурталчилгаа, мэдээ, мэдээллээр иргэдэд үйлчилсэн байна.

Жаргалант сумын Засаг даргын Тамгын газраас “Сайн үйлс сэтгэлийн дэм” аян, “Нийгмийн ажилтан бид таныг сонсож байна”, “Сэтгэлийн үгийг нь сонсьё” нээлттэй хаалганы өдөр, хэлэлцүүлэг, “Нийгмийн ажилтнуудын өнөөгийн байдал цаашдын чиг хандлага” сэдэвт илтгэл хэлэлцүүлэг хийсэн.12 багийн иргэдийн дунд аймгийн Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран Нийгмийн даатгалын хуулийг сурталчлах зорилгоор “Нийгмийн ажилтан гэж хэн бэ?, Ямар үүрэгтэй ажилладаг вэ? сургалт зөвлөгөөг зохион байгуулсан байна. Алаг толгой, Хайрхан, Буянт, Тахилт багууд хэсэгчилсэн байдлаар аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүдтэй хамтран Газрын тухай багц хууль сурталчилан санал асуулга авч хэлэлцүүлэг зохион байгуулж 1000 орчим иргэд оролцож, хашаагаа сунгасан айлуудын зөрчлийг арилгасан байна. Хайрхан, Алаг толгой баг “Хишиг өдөр нээлттэй хаалганы өдөр, Баатархайрхан, Бичигт багаас “Залуу гэр бүлийн хөгжил” сэдэвт хэлэлцүүлэгийг Азийн хөгжлийн сангийн төлөөлөгчтэй хамтран баг бүрээс 30 иргэн оролцуулан зохион байгуулсан.

Нээлттэй хаалганы өдрийн үйл ажиллагааны хүрээнд өрхийн эмнэлэгтэй хамтран “Сэтгэл хангалуун урт наслахад нөлөөлөх, эрүүл зан үйлд суралцъя” сэдэвт өдөрлөг цэнгүүн, “Хийн дасгалыг хэн сайн хийх вэ? тэмцээнийг ахмад настнуудын дунд Галдан бошгот хааны талбай дээр зохион байгуулсан.

Чандмань сумын Эрүүл мэндийн төв нь “Эх хүүхдийн тусламж үйлчилгээнд чанарыг сайжруулъя” сэдэвт нээлттэй хаалганы өдрүүдийг Сүлжээ, Тахилт багуудад зохион байгуулж, багийн иргэдийг ЭХО оношлогооны үзлэг шинжилгээнд хамруулан иргэдийн дунд эрүүл мэндийн боловсролыг олгох сургалт, семинари үзлэг оношлогоонд хамруулсан байна.Тахилт багаас багаа сурталчилах нэг өдрөөр малын гаралтай бүтээгдэхүүнээр хийсэн худалдаа зохион байгуулж, 8 төрлийн бүтээгдэхүүнээр 25 иргэнийг шалгаруулж шагнаан, урлагийн тоглолт, шоу цэнгүүн, спортын ыарга хэмжээ, эрүүл мэндийн үзлэг, сургалт сурталчилгаа зэргийг зохион байгуулсан байна.

2014 онд сум байгууллагаас зохион байгуулсан нээлттэй хаалганы өдрийн тоон мэдээг хавсаргав.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2014 ОНД СУМДЫН “НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР” БУЮУ
“ИРГЭДИЙН ӨДӨР” ЗОХИОН БАЙГУУЛСАН ТОО

\Сумын хэмжээнд\

2014.10.30

Ховд

Д/ д	Сумдын нэрс	Хэрэгжүүлсэн ажлын тоо
1	Алтай	6
2	Булган	13
3	Буянт	12
4	Дарви	5
5	Дуут	16
6	Дөргөн	7
7	Зэрэг	6
8	Манхан	12
9	Мөст	9
10	Мөнххайрхан	10
11	Мянгад	13
12	Үенч	3
13	Ховд	10
14	Цэцэг	2
15	Чандмань	3
16	Эрдэнэбүрэн	15
17	Жаргалант	15
	ДҮН	157

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2014 ОНД БАЙГУУЛЛАГА, АГЕНТЛАГУУДЫН “НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР” ”
БУЮУ “ИРГЭДИЙН ӨДӨР” ЗОХИОН БАЙГУУЛСАН ТОО

2014.10.30

Ховд

дд	Байгууллагын нэр	Хэрэгжүүлсэн ажлын тоо
1	Боловсролын газар	10
2	Нийгмийн даатгалын хэлтэс	4
3	Соёл, спорт, аялал жуулчлалын газар	3
4	Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс	16
5	Хөдөлмөрийн хэлтэс	3
6	Худалдан авах ажиллагааны хэлтэс	20
7	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс	8
8	Эрүүл мэндийн газар	4
9	Хөгжимт драмын театр	2
10	Нийтийн номын сан	9
11	Музей	7
12	Бүсийн оношлогоо, эмчилгээний төв	3
13	Байгаль орчны газар	10
14	Сум дундын ойн анги	12
15	Хар нуур, Ховд голын сав газрын захиргаа	3
16	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	12
17	Стандартчилал хэмжилзүйн хэлтэс	12
18	Тээвэр авто замын газар	6
19	Мэргэжлийн хяналтын газар	6
20	Газар хөтлөлтийг бүртгэх “Ховд” станц	2
21	Үйлдвэр хөдөө аж ахуйн газар	7
22	ХУНОУТХГН-ын хамгаалалтын захиргаа	5
23	Онцгой байдлын газар	11
24	Цагдаагийн газар	8
25	Шүүхийн шинжилгээний алба	3
26	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	2
27	Улсын бүртгэлийн хэлтэс	2
28	Татварын хэлтэс	6
29	Статистикийн хэлтэс	7
30	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүх	10
31	Ховд ИС	8
32	Хөгжил Политех коллеж	8
33	Ус цаг уур, орчны шинжилгээний төв	2
34	Зооноз өвчин судлалын төв	2
35	Прокурорын газар	1
36	Шүүх	6
		240

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

